



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 453

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 8,030,000.00 (найман сая гучин мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга Ж.Тамир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

13201660

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28 ны өдрийн 753 дугаар тогтоолын хавсралт

**ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ  
СУНГАЖ ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЭЛЭХ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛСАНСАД  
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиг лалтад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчилсэн үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Төхөөрөмж /гүйлтийн зам/	2012.10.01	ш	1	3,080,000.00	1,155,000.00	3
2	Төхөөрөмж /булчин-мер цээж/	2012.10.01	ш	1	1,870,000.00	701,250.00	3
3	Төхөөрөмж /хэвлийн хэсгийн/	2012.10.01	ш	1	825,000.00	309,375.00	3
4	Төхөөрөмж /өгзөгний хэсгийн /	2012.10.01	ш	1	825,000.00	309,375.00	3
5	Төхөөрөмж /гуяны хэсгийн /	2012.10.01	ш	1	550,000.00	206,250.00	3
6	Төхөөрөмж /нурууны татлагын/	2012.10.01		1	550,000.00	206,250.00	3
7	Төхөөрөмж /өргөлтийн штанг/	2012.10.01	ш	1	330,000.00	123,750.00	3
					8,030,000.00	1,856,250.00	-
<b>ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН</b>					<b>(найман сая гучин мянга)</b>	<b>(нэг сая найман зуун тавин зургаан мянга хоёр зуун тавин)</b>	